## СҮХБААТАР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /ХАГАС ЖИЛ/

### НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тогтвортой газар ашиглалтад чиглэсэн нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| **1.1.1** | **Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах** | **Улсын төсөв 1200.0 сая** | **Батлагдсан улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө** | **Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан.** | **Төлөвлөгөөний төслийг боловсруулах, улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлээс төслийг хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийг ЗГ-т өргөн барьж батлуулсан байна.** | | | |
| 1.1.1.2 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчилж хийсэн байна. | Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Ерөнхий төлөвлөгөөний аргачлалд санал өгч ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. **Жилийн эцэст:** Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл, судалгааг гаргаж гүйцэтгэгчид болон | | Зөвлөх үйлчилгээг зарласан одоогоор гүйцэтгэгч шалгараагүй байгаа тул гүйцэтгэгчийг мэдээллээр хангаж ажиллах боломжгүй байна. | **90** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br>Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлгөөтэй уялдуулан тусгагдсан арга хэмжээг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн, зөв зурагласан эсэхэд хяналт тавьсан байна.<br>ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгүүлэх, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, саналыг тусгах ажлыг зохион байгуулсан байна. | | | |
| **1.1.2** | **Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах** | **Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр** | **Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөө шинэчилсэн болон нэмэлт тодотгол хийсэн аймгийн тоо** | **Нийслэл болон 19 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан.** | **Хөвсгөл, Ховд, Өвөрхангай, Увс аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, Дархан-Уул, Говьсүмбэр, Дорноговь аймгуудын төлөвлөгөөнд тодотгол хийсэн байна.** | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2.3 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах. | Үйл ажиллагаа | **Сүхбаатар** | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. | **Эхний хагас жилд:**<br><br>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна.<br><br>**Жилийн эцэст:**<br><br>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна. Хэрэгжилтийг 12 дугаар сарын 20-ны дотор тайлагнасан байна. | | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн газар, Байгаль орчины газар, сумдын Засаг даргын тамгын газруудаас 2025-2028 оны хугацаанд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гаргуулж нэгтгээд байна. Мөн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 32 нэгж талбарыг хэрэгжүүлэхээр тусгаад байна. | 100 |
| **1.1.3** | **Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах** | **Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр** | **Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан сумдын тоо** | **9 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдсэн** | **0 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан байна.** | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3.1 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах. | Үйл ажиллагаа | Сүхбаатар, аймгийн 11 сум | Аймгийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 12 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. | **Эхний хагас жилд:**<br><br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.<br><br>**Жилийн эцэст:**<br><br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг 12 дугаар сарын 20-ны дотор цахим системд байршуулсан байна. | | Мөнххаан суманд даацыг тохируулах бэлчээр 11, сэлгэж ашиглах бэлчээр 4, өнжөөж амраах бэлчээр 2, хөв цөөрөм байгуулж ашиглалтыг нэмэгдүүлэх бэлчээрийн газрын төлөвлөлт 1, хадлангийн газрыг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх газар 2, мод бут, сөөг тарих 2, ойжуулалт хийх ойн талбай 1, тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах газар 1, усны эх булаг, эрэг орчмын газрыг хашиж хамгаалах 4, Сүхбаатар суманд Сэлгэж ашиглах бэлчээр 1, Түмэнцогт суманд Хадлангийн газрыг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх газар 1, Хот суурины эдэлбэр доторх ойн сан бүхий газар 1, Усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс 1, нийт 11 арга хэмжээний 32 нэгж талбарыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусган батлуулаад байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2. Бүсчилсэн хөгжлийг дэмжиж, төвлөрлийг сааруулах Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн оновчтой хуваарийг тогтоох** | | | | | | | | |
| **1.2.1** | **Хот байгуулалтын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Газрын тухай хууль, тогтоомж холбогдох норм, дүрэмд нийцүүлэн хотын эдэлбэр газрыг тогтоох ажлыг зохион байгуулах** | **Улсын төсөв** | **Эдэлбэр газрыг тогтоосон хот, тосгон бусад суурин газрын тоо** | **Нийслэл Улаанбаатар хотын эдэлбэр газрыг тогтоосон** | **21 аймаг, 330 сум, 12 хилийн боомтын эдэлбэр газрыг тогтоосон байна.** | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1.2 | Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, танилцуулгаар хангаж төлөвлөгөөний зардлыг төсөвт суулгах ажлыг аймгийн Ерөнхий архитектортой хамтран зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сүхбаатар, аймгийн 10 суманд төлөвлөгөө хийгдэж 1 суманд тодотгол 2 сумын ХЕТөлөвлөгөө боловсруулах | Аймгийн хэмжээнд 10 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж 1 суманд тодотгол хийгдэж байна. 2 суманд ХЕТөлөвлөгөө хийгдэнэ. | **Эхний хагас жилд:**<br>Хотын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгуулах талаарх саналаа төсвийн тооцоолол болон танилцуулгын хамт сумын ИТХ, Засаг даргад хүргүүлсэн байна.<br>Жилийн эцэст: 13 суманд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон байна. | | Сүхбаатар аймгийн хэмжээнд 2 суманд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажил хийгдэж байна. Баруун-Урт сумыг орон нутгийн төсвийн 715 сая/төг санхүүжилтаар Нью урбанизм ХХК гүйцэтгэж дундын шатны тайланг танилцуулж хүлээлгэж өгөх шатандаа явагдаж байна. Энэ онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэцагаан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажил хийгдэж гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатандаа явагдаж байна.<br>Сүхбаатар, Онгон, Уулбаян сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Ланд овнер” ХХК, Арт констракшн ХХК-нууд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж батлуулах шатандаа явагдаж байна. Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 480.0 сая/төг хөрөнгө оруулалтаар Дарьганга, Наран, Түвшинширээ, Асгат сумдын төлөвлөгөөг Ди Ди Эй Жи ХХК, Арт констракшн ХХК-нууд гүйцэтгэж эхлэлийн болон дундын шатны тайлан мэдээг ерөнхий архитектороор хянуулан оролцоог хангаж ажиллаж байна.<br>Мөнххаан, Халзан сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2025 оны 01 сарын 23-ний өдрийн 04 тогтоолоор баталгаажуулж хүлээн аваад байна. | 100 |
| 1.2.1.3 | “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д батлагдсан болон боловсруулж байгаа Хот байгуулалтын баримт бичгийг бүртгэх ажлыг аймгийн Ерөнхий архитектортой хамтран зохион байгуулах | Үйл ажиллагаа | Батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг цахим системд бүртгэнэ. | Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд батлагдсан хөгжлийн ерөнхий системд бүртгэгдсэн байна. | **Эхний хагас жилд:**<br>-Батлагдсан болон боловсруулж байгаа хотын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний орон зайн мэдээлэл, тоон өгөгдлийг “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д оруулах<br>**Жилийн эцэст:** | | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 сарын 23-ны өдрийн хуралдаанаар “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 04 дугаартай тогтоолоор Мөнххаан, Халзан сумдын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталж хүлээн авсан.<br>“Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д Мөнххаан сум 2021-09-022-7426 төслийг үүсгэн 273 нэгж талбар, Халзан сум 2021-09-022-7427 төслийг үүсгэн 146 нэгж талбарыг бүртгэснийг аймгийн ерөнхий архитектор хянах ажлыг хийж гүйцэтгэж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хот, тосгоны батлагдсан хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг бүрэн хамруулж Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэсэн байна. | | Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа сумдаас Онгон сум 2024-09-022-7960 төслийг үүсгэн 1 нэгж талбар, Сүхбаатар сум 2024-09-022-7959 төслийг үүсгэн 123 нэгж талбарыг боловсруулах шатанд оруулж хянуулж ажиллаж байна. | |
| **1.2.2** | **Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг геодезийн солбицлоор тогтоон, баталгаажуулах ажлыг үе шаттай зохион байгуулах** | **Улсын төсөв** | **13 сум,** | **Улсын хэмжээнд хилийн цэсийн 13444 эргэлтийн цэгийн солбицлыг тогтоосон** | **Хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийн солбицлыг засаг захиргааны нэгж тус бүрээр боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.** | | | |
| 1.2.2.1 | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн байгалийн хил зааг, хүний гараар бүтээгдсэн объектоор тогтоосон хэсгийн судалгаа хийх | Үйл ажиллагаа | Сүхбаатар аймаг | Аймгийн хэмжээнд хилийн цэсийн 3 эргэлтийн цэгийн солбицлыг тогтоосон | **Эхний хагас жилд:**<br>Байгалийн хил зааг, хүний гараар бүтээгдсэн объектоор тогтоосон хилийн цэсийн судалгааг гаргах. | | Байгалийн хил зааг, хүний гараар бүтээгдсэн объектоор тогтоосон хилийн цэсийн судалгааг гаргаж хүргүүлсэн. | |
| 1.2.2.4 | Монгол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс, заагийн цахим системд багийн хилийн | Үйл ажиллагаа | Сүхбаатар аймаг | Цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Цахим системд урьд онуудад үүссэн хилийн цэсийн маргааны талаарх | | Эрдэнэцагаан сумын багийн хилийн зааг Газрын кадастрын мэдээллийн санд ганцхан багаар орсныг засуулахаар сумын ИТХ-ын тогтоолыг багийн хилийн заагийг тогтоосон солбицол, shp файлыг үүсгэн, мөн Дарьганга суманд шинэ баг байгуулагдсантай холбогдуулан Аймгийн ИТХ- | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | заагийг тогтоосон ИТХ-ын тогтоол, хилийн цэсийн маргааны талаарх холбогдох архивын баримт материалыг бүртгэх ажлыг орон нутагтаа зохион байгуулах | | | | статистик тоон мэдээ, маргаан шийдвэрлэсэн тухай холбогдох баримт материалыг хилийн цэсийн эргэлтийн цэг бүрээр нөхөн бүртгэх, багийн хилийн зааг тогтоосон аймаг, сумын ИТХ-ын тогтоолыг баг тус бүрээр оруулж цахим архив үүсгэх.<br>**Жилийн эцэст:**<br>2025 онд үүссэн хилийн цэсийн маргааныг цахим системд бүртгэж, орон нутагдаа шийдвэрлэх ажлыг зохион байгуулах,<br>Цахим системийг орон нутгийн удирдлага, олон нийтэд сурталчлах, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулах. | | аар батлагдсан Дарьганга сумын багийн хилийн заагийн тогтоол, холбогдох бичиг баримтыг Хилийн цэсийн мэдээллийн санд бүртгүүлэхээр албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | |
| 1.2.2.5 | Аймгийн төвтэй ойр сумдын судалгааг гаргаж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тодотгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хилийн цэсийг тэлэх саналыг аймаг, сумын ИТХ-аар | Үйл ажиллагаа | 4 сум | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсан | **Эхний хагас жилд:**<br>-<br>**Жилийн эцэст:** Аймгийн төвтэй ойр сумдын судалгааг гаргаж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тодотгох шаардлагатай эсэх | | Аймгийн төвтэй ойр Сүхбаатар, Асгат, Халзан, Уулбаян сумын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тэлэх саналгүй байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлэлцүүлж ГЗБГЗЗЕТ-т ирүүлэх. | | | | тандан судалгааг хийж, хилийн цэсийг тэлэх саналыг аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлж ГЗБГЗЗЕГ-т ирүүлсэн байна. | | | |
| **1.4.4** | **GNSS-ийн байнгын ажиллагаатй суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах** | **Үйл ажиллагаа** | **2 станц** | **2013-2024 онд Улсын төсвөөр 43, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан.** **2024 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 48 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах ажлыг зохион байгуулна.** | | | |
| 1.4.4.1 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байнгын ажиллагаатай станц-2 | 2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн. 2024 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 1 станцыг нэгдсэн удирдлагын тогтолцоонд нэмсэн. | **Эхний хагас жилд:** GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах ажлыг зохион байгуулсан байна. **Жилийн эцэст:** GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 станцын үйл ажиллагаа тасарсан тухай бүр шалтгааныг тодруулж хэвийн ажиллагааг хангах шаардлагатай арга хэмжээг зохион байгуулсан байна. | | Тус аймгийн СҮА-1, СҮА-2 GNSS-ийн байнгын ажиллагаатай станцуудын тасралтгүй хэвийн ажиллагааг monpos.gazar.gov.mn сайтаар дамжуулан тогтмол хяналт тавьж ажилласан. СҮА-2 GNSS-ийн эх хавтан гэмтсэн тул орон нутгийн төсвөөр яаралтай засварлах шаардлагатай гэсэн чиглэл ирсний дагуу ГХБХБГ-ын 2024 оны 1/501 тоот албан бичгээр Сүхбаатар аймгийн засаг дарга М.Идэрбат-д 2025 оны орон нутгийн төсөвт СҮА-2 станцыг засварлах 18480000 төгрөгийг тусгуулах хүсэлтийг хүргүүлсэн ч тус оны төсөвт тусгагдаагүй. Тус эх хавтанг ГЗБГЗЗЕГ-аас шийдвэрлэж өгөхөөр болсон. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.4.2 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хяналтын хэмжилт нэгтгэх | Үйл ажиллагаа | Бодит агшны хяналтын хэмжилт - 2 станц | Аймгийн төвд 1 геодезийн тулгуур сүлжээний цэг, тэмдэгтийг суурилуулсан. | **Бүтэн жилээр:**<br>GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 станцын аймгийн төвд суурилуулсан станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 1 удаагийн шалгалтын хэмжилт, сум суурин газрын станцуудад хагас жилд 1 удаагийн шалгалтын хэмжилт хийнэ. | | СҮА-1 байнгын ажиллагаатай станцын 1 дүгээр улирлын бодит агшны хяналтын хэмжилтийг 3 дугаар сарын 21-ний өдөр, 2 дугаар улирлын хяналтын хэмжилтийг 05 дугаар сарын 30-ний өдөр ГЦТ5338, ГЦТ1812, ГЦТ6571, ГЦТ0013, ГЦТ0046 цэгүүд дээр тус бүр 3 удаа гүйцэтгэн үр дүнг тэгшитгэн бодож тайланг \\192.168.20.24\Geodesy\GNSS хяналт хэмжилт 2025 серверт байршуулсан. | 100 |
| **1.4.6** | **Геодезийн байрлал, өндөр, гравиметр, GNSS-ийн сүлжээний ITRF2008 солбицлын тогтолцоонд тодорхойлсон цэг тэмдэгтийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх, Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн санг хөтлөх.**<br>**Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Улсын хэмжээнд нийт 22000 орчим цэг тэмдэгт** | **Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.** | **Геодезийн байрлал, өндөр, гравиметр, GNSS-ийн сүлжээний ITRF2008 солбицлын тогтолцоонд тодорхойлсон цэг тэмдэгтийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.**<br>**Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлнө.**<br>**Геодезийн цэг тэмдэгтийн цахим системийн шинэчлэлтэд хяналт тавьж, 21 аймгаас** | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **ирүүлсэн хүсэлтийг баталгаажуулна.** | | | |
| 1.4.6.1 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх | Үйл ажиллагаа | - GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээний - 2 цэг, тэмдэгт<br>- Өндөр болон гравиметрийн сүлжээний 1 репер, цэг | Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн. | **Бүтэн жилд:**<br>Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлнө.<br>Цахим системийн шинэчлэлтэд хяналт тавьж, ирүүлсэн хүсэлтийг баталгаажуулна. | | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санд бүртгүүлэх хүсэлт ирээгүй байна. | - |
| 1.4.6.2 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Нөхөн сэргээсэн цэгийн тоогоор<br>(- GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээний цэг, тэмдэгт<br>- Өндөр болон гравиметрийн сүлжээний репер, цэг) | 2019 онд Газрын даргын А/291 дугаар тушаалаар “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх” журмыг баталсан. | **Эхний хагас жилд:**<br>Нөхөн сэргээсэн цэг тэмдэгтийн хүсэлт ирүүлсэн тухай бүрд хүлээн авч, цахим санд оруулна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Нөхөн сэргээсэн цэг тэмдэгтийн хүсэлт ирүүлсэн тухай бүрд хүлээн авч, цахим санд оруулна.<br>21 аймаг, нийслэлийн геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллогын мэдээллийг цахим санд оруулсан үр дүнд хяналт тавьж, баталгаажуулна. | | Аймгийн болон 13 сумын төвд байрлах 64 цэг тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг шалган, элс шороонд дарагдсан цэгийн ойр орчмыг цэвэрлэн канавыг ухаж сэргээх ажлыг гүйцэтгэсэн. | 100 |

| Стратеги төлөвлөгөөний зорилго 1.5. Монгол Улсын нутаг дэвсгэрийг төрөл бүрийн масштабтай газрын зургаар зурагжуулах, газар зүйн нэрийг тодруулах | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.5.1** | **1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зургийг шинээр гүйцэтгэх.** | **Улсын төсөв** | **1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зураг** | **Нийслэл, Өмнөговь аймгийн төв, 4 сумын төвийг ITRF2020 тогтолцоонд 1:1000-ны масштабтай тоон байр зүйн зургийг 2024 онд шинээр гүйцэтгэж байна.** | **ITRF2020 тогтолцоонд 21 аймгийн 330 сум, 45 суурин, Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай тоон байр зүйн зургийг шинээр гүйцэтгэсэн байна.** | | | |
| 1.5.1.1 | Том масштабын байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний зураглал хийх | Орон нутгийн төсөв | 2 сумын зураглалын ажлын даалгавар, зураглал | Аймгийн хэмжээнд 13 сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг 2017 онд зурагласан. | **Эхний хагас жилд:** 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх ажлын төсвийн тооцоог гарган, танилцуулга бэлтгэж, ажлын даалгаврын төслийг боловсруулна.<br>**Сүүлийн хагас жилд:** 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх ажлыг 2026 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар төсвийн | | 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх ажлын төсвийн тооцоог гарган аймгийн ХОХБТХэлтэс болон аймгийн Засаг даргад танилцуулсан боловч орон нутгийн төсөвт тусгагдаагүй.<br>Мөн Баруун-Урт сумын үерийн далангийн зураг хийлгэх ажлын хүрээнд дэвсгэр зургийг шинэчлэх ажлыг тус ажлын бүрдэл хэсэгт оруулан ХОХБТХэлтэст хүргүүлээд байна. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооцоо, танилцуулга, ажлын даалгаврын төслийг Аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж, Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлнэ. | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.7. Газрын нэгдмэл санг эрхлэх, газрын нэгдмэл сангийн цахим системийг хөгжүүлэх** | | | | | | | | |
| **1.7.1** | **Монгол Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн үйл ажиллагааг зохион байгуулж, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах, тайлагнах** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл хийх эрх зүйн орчин бүрдэж, өөрчлөлт, шилжилтэд хяналт тавих, тайлагнах боломж бүрдсэн байна.** | **Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн ангилал, шилжилт хөдөлгөөний тайланг гаргасан.** | **Газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, тайлагнах боломж бүрдсэн байна.** | | | |
| 1.7.1.1 | Байгаль орчны төлөв байдлын БОХ-1.1, БОХ-1.2 тайланг гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | 2024 оны БОХ-1.1, БОХ-1.2 тайлан | Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан. | **Эхний хагас жилд:**<br>2024 оны БОХ-1.1, БОХ 1.2 тайланг гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | | Байгаль орчны төлөв байдлын 2024 оны БОХ-1.1, БОХ-1.2 тайланг 2025 оны 01 сарын 08-ны өдөр munkhtstsg.do@gmail.com хаягаар илгээсэн. | **100** |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8. Хот байгуулалтын кадастрын цахим системийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.8.1** | **Хот байгуулалтын кадастрын цахим системд өгөгдөл, мэдээлэл бүртгэх** | **Үйл ажиллагаа** | **Өгөгдөл мэдээлэл** | **2024 онд программ хөгжүүлэх ажил хийгдсэн.** | **21 аймгийн 330 сумын барилга байгууламж, ИШС, тохижилт ногоон байгууламжийн өгөгдөл мэдээлэл хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэгдсэн байна.** | | | |
| 1.8.1.1 | Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжих инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл, төлөвлөлтийн давхаргын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хот байгуулалтын цахим системд бүртгэнэ . | Сургалт зохион байгуулж мэдээллийн санд бүртгэх. | **Эхний хагас жилд:**<br>Төлөвлөлтийн давхаргуудын мэдээллийг бүртгэсэн байна<br>**Жилийн эцэст:**<br>Хот байгуулалтын кадастрын системд төлөвлөлтийн давхаргын мэдээлэлийг бүртгэгдсэн байна. | | Сүхбаатар аймгийн хэмжээнд инженерийн шугам сүлжээг мэдээллийн санд бүртгэх ажлын хэсгийг байгуулж анхны хурлыг 2025 оны 02 дугаар 1-ны өдөр хуралдаж хангагч байгууллагад эрх нээлгэх талаар мэдээлэл бүртгэх маягтын дагуу ГЗБГЗЗЕГазар хүргүүлэн ажилласан. Системийн хөгжүүлэлтэй холбоотойгоор эрх нээгдээгүй байна. Мэдээллийн сантай холбоотой санал хүсэлтийг хөгжүүлэгч байгууллага болон хариуцсан мэргэжилтэнд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Хагас жилийн байдлаар улс болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжиж буй Уулбаян сумын 150 хүүхдийн цэцэрлэг, Түвшинширээ сум 320 хүүхдийн сургууль, Халзан сум Амбулторын өргөтгөлийн барилга, Баруун-Урт сум 640 Хүүхдийн сургууль, Асгат сум Ахуй үйлчилгээний барилга, цахим системд бүртгэж ажилласан. Харин Дарьганга сум Сумын төвийн төвлөрлөсөн шугам сүлжээ, Дарьганга зуслангийн орчин үеийн стандартад нийцүүлсэн амралт, аялжуулчлалын цогцолборын шинэчлэл шугам сүлжээний ажил Асгат сум дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга зэрэг ажлуудын төлөвлөлтийн давхаргыг мэдээллийн санд бүртгэх ажил хийгдэж байна. | 100 |
| 1.8.1.2 | Инженерийн шугам сүлжээний | Үйл ажиллагаа | Стандартын дагуу оруулах | Улс орон нутгийн | **Эхний хагас жилд:** | | Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн А/24 тоот захирамжаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалалт, хориглолтын бүсийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэн оруулах ажлыг зохион байгуулах | | | төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг мэдээллийн санд бүртгэнэ. Системд бүртгэгдсэн хамгаалалтын зурвас одоогоор байхгүй байна. | Инженерийн шугам сүлжээний хамгаалалт, хориглолтын бүсийн мэдээллийг бүртгэсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Хот байгуулалтын кадастрын системд инженерийн шугам сүлжээний хамгаалалт, хориглолтын бүсийн 7 давхаргын мэдээлэл бүртгэгдсэн байна. | | батлагдсан ажлын хэсгийг шинэчлэн байгуулж хуралдуулхаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| 1.8.1.3 | Тэг тэнхлэг улаан шугам, барилга, инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэн оруулах ажлыг зохион байгуулах. | Үйл ажиллагаа | Тэг тэнхлэг, байрзүйн гүйцэтгэлийн зураг 2 давхарга | Мэдээллийн санд бүртгэнэ | **Эхний хагас жилд:**<br>Тэг тэнхлэг улаан шугам болон инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийн мэдээллийг бүртгэсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Тэг тэнхлэг улаан шугам болон инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийн 2 давхарга мэдээлэл бүртгэгдсэн байна. | | Хагас жилийн байдлаар Баруун-Урт суманд Шинэ тэмүүлэл хотхоны Б блок 56 айл үйлчилгээтэй орон сууц, Цэлмэг аппартмент “А” блокын орон сууц, Мөнххаан сум Өдрийн Аз ХХК 4 давхар орон сууцны барилга, Дарьганга сум 1-р баг Өрнөдэрс Ганга нуур аялал жуулчлалын цогцолбор газрын гадна цахилгаан хангамж, Уулбаян сум 150 хүүхдийн цэцэрлэг, Түвшинширээ сум 320 Хүүхдийн сургууль, Баруун-Урт сум 640 Хүүхдийн сургууль, Халзан сум Амбулоторын өргөтгөлийн барилга, Асгат сум ахуйн үйлчилгээний барилга зэрэг ажлуудыг цахим системд бүртгэж ажилласан. | **100** |
| 1.8.1.4 | Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын | Үйл ажиллагаа | Мэдээллийн санд бүртгэнэ | Мэдээллийн санд бүртгэнэ | Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний 45 | | Хагас жилийн байдлаар цахим системд Баруун-Урт суманд 2,4,5 дугаар тойргийн авто зам, түүний байгууламж, Шинэ тэмүүлэл хотхоны Б блок 56 айл үйлчилгээтэй орон сууц, Цэлмэг аппартмент “А” блокын 54 айлын орон сууц, Мөнххаан сум Өдрийн Аз ХХК 4 давхар орон сууцны барилга, Дарьганга сум 1-р баг Өрнөдэрс Ганга нуур аялал жуулчлалын цогцолбор газрын | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сүлжээний өгөгдөл мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах | | | | давхаргын өгөгдөл мэдээлэл бүртгэгдсэн байна | | гадна цахилгаан хангамж зэргийн ажлыг цахим системд бүргтгэж ажилласан. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.9. Газрын биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, үйл ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | | |
| **1.9.1** | **Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг бий болгоно.** | **Үйл ажиллагаа** | **Цахим үйл ажиллагаатай Газрын бирж** | **Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.** | **Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.** | | | |
| 1.9.1.2 | Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо | Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | **Жилийн турш:** Тухайн жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөвлөсөн газарт зохион байгуулсан байна. | | 2025 онд 7 суманд 24-н байршилд газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа явуулахаар төлөвлөсөн. Одоогийн байдлаар Эрдэнэцагаан /цахим/, Сүхбаатар /танхим/ суманд 13-н нэгж талбарын дуудлага худалдааг зохион байгуулж 7-н байршлын дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулан 969.59 сая төгрөгийн орлогыг аймаг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. 6 нэгж талбарын дуудлага худалдаа оролцогчгүй, ялагч гэрээ байгуулаагүй, мөнгө төлөөгүйн улмаас хүчингүй болсон. Мөн Сүхбаатар суманд 3-н байршлын төсөл сонгон шалгаруулалт 6 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөгдсөн байна. | 100 |
| 1.10.1.4 | Газрын төлбөр, татварын цахим системээр нийт нэгж | Үйл ажиллагаа | Нийт хүчинтэй гэрээний тоо | Газрын төлбөр, татварын | **Эхний хагас жилд:** Хуульд заасан хугацаанд Татварын | | Энэ онд аймгийн хэмжээнд 2471 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт хийгдсэн бөгөөд үүнээс 2365 нэгж талбарт газрын төлбөрийн | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | талбарт төлбөр бодох, ногдуулалт хийж, нэхэмжлэх үүсгэх, газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээх авах ажлыг зохион байгуулах | | | системийг нэвтрүүлсэн. | нэгдсэн системд бүх ногдуулалтыг илгээсэн байна. | | нэхэмжлэх амжилттай үүсгэж харъяалах татварын байгууллагад илгээсэн. Одоогийн байдлаар газрын төлбөрийн нэхэмжлэх 95.7 хувьтай байна. Алдаатай ногдуулалтуудыг сум тус бүрээр засварлах ажил үе шаттай хийгдэж байна. Газрын татвар ногдуулалт 8717 нэгж талбарт хийгдсэнээс 8238 нэгж талбарт нэхэмжлэх үүсгэж татварын хэлтэст илгээсэн, Газрын татварын нэхэмжлэх 94.5 хувьтай үүссэн байна. | |
| 1.11.1.1 | Газрын үнэлгээний цахим системийн газрын нөхөх олговрын мэдээллийн санг бүрдүүлэх, нөхөх олговортойгоор газар чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын нөхөн бүрдүүлэлт хийх, мэдээллийн сан хөтлөх | Үйл ажиллагаа | Нөхөх олговор олгож чөлөөлсөн газрын тоо | Газрын үнэлгээний системийг хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговортойгоор чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын мэдээллийн санг бүрдүүлэх.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговортойгоор чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын мэдээллийн санг бүрдүүлэх. | | Баруун-Урт сумын 9 дүгээр баг Хайлаастад шинээр тавигдсан авто замын хамгаалалтын зурваст орсон 4-н иргэний өмчлөлийн газрыг 2024 онд чөлөөлсөн. Газар, барилга, үнэлгээний мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэхэд зориулж аймгийн төрийн сангаас нийт 271389622 төгрөгийн зардал гаргасан. Уг газруудын мэдээллийг нөхөн бүртгэж, мэдээллийн сан үүсгэв. | 100 |
| 1.11.1.3 | Үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч байгууллагаас газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээлэл, Газар, үл хөдлөх хөрөнгийн барьцааны болон нөхөн олговрын үнийн мэдээлэл, зах зээлийн санал болгосон буюу зарлан мэдээлсэн | Үйл ажиллагаа | эрх шилжсэн тоо | Кадастрын мэдээллийн нэгдсэн системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | **Эхний хагас жилд:**<br>Газрын биржийн цахим системд эрх шилжсэн газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна.<br>**Жилийн эцэст:** | | Газрын биржийн цахим системд эрх шилжсэн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ Баруун-Урт сум 13, Халзан сум 3 тус тус цуглуулж дүн шинжилгээ хийгдсэн. Аймгийн төв Баруун-Урт суманд хашаагүй 0.07 га газрын зах зээлийн үнэ урьд оноос 25 хувиар буурсан үзүүлэлттэй харагдаж байна.<br>Мөн оны эхний хагас жилд аймагт хөрөнгийн үнэлгээний чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг “Болор үнэлгээ” ХХК-иар 6 суманд 26 иргэн үйлчлүүлж үл хөдлөх хөрөнгө, газраа үнэлүүлсэн байна. Тус компани нь одоогийн байдлаар 0.07 га газар, үл хөдлөх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үнийн мэдээллийг тус тус цуглуулах | | | | Газрын биржийн цахим системд эрх шилжсэн газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна. | | хөрөнгийг 300000 төгрөгийн өртөгтэйгөөр үнэлгээ хийж байна. | |
| 1.11.1.4 | Зах зээлийн үнийн мэдээг газрын үнэлгээний системд оруулж дүн шинжилгээ хийх, масс үнэлгээ тооцох | Үйл ажиллагаа | эрх шилжсэн тоо | Газрын үнэлгээний системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг үнэлгээний цахим системд оруулж дүн шинжилгээ хийсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг үнэлгээний цахим системд оруулж дүн шинжилгээ хийсэн байна. | | Газрын биржийн цахим системд эрх шилжсэн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ Баруун-Урт сум 13, Халзан сум 3 тус тус цуглуулж дүн шинжилгээ хийж масс үнэлгээг тооцоолсон. | |
| 1.11.1.5 | Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг | Үйл ажиллагаа | Дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговор олгож чөлөөлсөн газрын тоо | Газрын үнэлгээний системийг хэрэглээнд нэвтэрсэн | **Жилийн эцэст:**<br>Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, | | Эхний хагас жилд Халзан суманд 2 иргэнээр дуудлага худалдааны анхны үнэ 503920 төгрөгийг төлүүлж төлөлтийг газрын үнэлгээний системд бүртгэн, мэдээллийн сан үүсгэсэн. Нөхөх олговороор олгосон, чөлөөлсөн газрын мэдээлэл байхгүй. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэх; | | | | чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэсэн байна. | | | |
| 1.11.1.6 | Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэсэн нэгж талбарт газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэх | Үйл ажиллагаа | Тусгай зөвшөөрөл олгосон тоогоор | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br><br>Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэсэн газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэсэн байна.<br><br>**Жилийн эцэст:**<br><br>Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэсэн газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэсэн байна. | | Аймгийн хэмжээнд нийт 26 уул уурхайн компанийн 65 хүчинтэй нэгж талбар газрын кадастрын цахим системд бүртгэлтэй байна. Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхээ баталгаажуулах хүсэлт иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлээгүй бөгөөд энэ төрлийн газрын төлбөрийн ногдуулалтад өөрчлөлт ороогүй болно. | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.11.1.7 | Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар иргэд, олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагаа | Олон нийтэд сурталчилсан ажлын тоо | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Жилийн турш:**<br><br>Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх боломжуудыг иргэд, олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулсан байна. | | Тус газраас үйлчлүүлж байгаа Баруун-Урт, Баяндэлгэр, Дарьганга, Уулбаян, Халзан сумдын иргэдэд газрын кадастрын egazar.gov.mn, газрын биржийн цахим систем mle.mn, ebargimt.mn сайтуудыг ашиглан газар эзэмших гэрчилгээ, гэрээ, кадастр хэвлэх газрын төлбөр, татварын төлөлт хийх, нэгж талбарын тодорхойлолт, газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт, барьцааны лавлагаа хэрхэн хэвлэх талаар нийт 190 гаруй иргэдэд заавар, зөвлөгөө өгч ажилласан. Мөн энэ оны 5 дугаар сарын 21-нээс 22-ний өдрүүдэд Эрдэнэцагаан суманд томилолтоор ажиллах хугацаандаа дээрх цахим системийн зааврыг 40 гаруй иргэдэд заавар зөвлөмж өгөв. | **100** |
| 1.11.1.8 | Төлбөрийн даалгавар үүсгэн улсын тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Эрх шилжүүлсэн, барьцаалсан, эзэмших, ашиглах эрх олгосон, хугацаа сунгасан нэгж талбарын тоогоор | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br><br>Газар эзэмших эрх шилжүүлсэн, барьцаалсан, эзэмших, ашиглах эрх олгосон, хугацаа сунгасан нэгж талбарын тоогоор улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна.<br><br>**Жилийн эцэст:**<br><br>Эрх шилжүүлсэн, барьцаалсан, эзэмших, ашиглах эрх олгосон, хугацаа сунгасан нэгж талбарын тоогоор улсын тэмдэгтийн хураамжийн | | Газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлт 8 суманд 17 хийгдэж 102.0 мянган төгрөг, Газар эзэмших эрхийн гэрчилгээ барьцаалсан бүртгэл 8-н суманд 66 хийгдэж 660.0 мянган төгрөг, газар эзэмших эрхийн хугацаа сунгасан хүсэлт 2 бүртгэгдэж 24.0 мянган төгрөг, газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны бүртгэл 2 суманд 57 хийгдэж 712.5.0 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн. Аймаг орон нутгийн төсөвт нийт 1498.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ. Газар эзэмших эрхийн төсөл сонгон шалгаруулалт Сүхбаатар суманд 3 төлөвлөгдсөн боловч зарлагдаагүй байна. | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.12. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, газрын харилцааны салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах** | | | | | | | | |
| **1.12.1** | **Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх** | **Улсын төсөв 185,0 сая төгрөг** | **Хяналт шалгалтад хамруулсан объектын гүйцэтгэлийн хувь,**<br>**Илэрсэн зөрчил арилалтын хувь,**<br>**Хууль сахин мөрдөлтийн түвшин;** | **2024 онд хяналт шалгалтад хармагдах объектын 90 хувийг хамруулсан.**<br>**Илэрсэн зөрчлийн 73,9%-ийг арилгуулсан. Хууль сахин мөрдөлтийн түвшин 78,1% байна.** | **Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хяналт шалгалт хийж, эрсдэлийн түвшин болон хууль сахин мөрдөлтийн хувийг бууруулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.** | | | |
| 1.12.1.1 | Улсын хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 14 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх, эрсдэлийн түвшин бууруулж, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн | Үйл ажиллагаа | Хяналт шалгалтад хамруулсан объектын гүйцэтгэлийн хувь,<br>Илэрсэн зөрчил арилалтын хувь,<br>Хууль сахин мөрдөлтийн түвшин; | 2024 онд хяналт шалгалтад хармагдах объектын 90 хувийг хамруулсан.<br>Илэрсэн зөрчлийн 75.0%-ийг арилгуулсан.<br>Хууль сахин мөрдөлтийн | Төлөвлөгөөт хяналт шалгалтад их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектын 95 хувийг бүрэн хамруулсан байна.<br>Эрсдэлийн түвшин болон хууль сахин мөрдөлтийн хувийг бууруулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн | | ГЗБГЗЗЕГ-ын даргын баталсан 35-00/01 дугаартай “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу аймгийн ЗДТГ, Байгаль орчны газар, Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран Сүхбаатар, Эрдэнэцагаан, Асгат сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төлөвлөгөөт хяналт шалгалт төлөвлөгдсөн Дорнын чулуулаг ХХК, Эрдэнийн Олз ХХК, Нагааранз ХХК, АДАЭ ХХК, Премиумкөүл корпараци ХХК-ниудын газар эзэмшил, ашиглалтын байдалд 35.2 коптой “Хот тосгон, бусад суурин газарт газар өмчлөгч, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | биелэлтийг хангуулах | | | түвшин 80.3% байна. | биелэлтийг бүрэн хангуулж, илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. | | эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгах" хяналтын хуудсаар эрсдлийн үнэлгээ хийхэд Дорнын чулуулаг ХХК 19%-ийн бага, Эрдэнийн Олз ХХК 51%-ийн их, Нагааранз ХХК 32%-ийн дунд, АДАЭ ХХК 30%-ийн дунд, Премиумкөүл корпараци ХХК 37%-ийн дунд эрсдэлтэй үнэлэгдлээ. Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудын эрсдэлийн үнэлгээний дундаж 33.8, хууль тогтоомжийн дундаж 74.4 хувьтай хэрэгжиж байна. Хяналт шалгалтаар нийт 33 дутагдал илрүүлж 28 заалттай 5 албан хугацаатай шаардлага өглөө. | |
| 1.12.1.3 | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, холбогдох баримт бичиг (тусгай зөвшөөрөл, хүний нөөц)-т урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | 2024 онд салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй 1 ААНБ, Геодезийн тусгай зөвшөөрөлтэй 2 ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт гүйцэтгэсэн. Үүнээс 2 объект бага эрсдэлтэй үнэлэгдсэн.<br>Эрсдэл үүсэх магадлалын хувь 6.3, хууль сахин мөрдөлтийн | Орон нутгийн хэмжээнд батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br><br>Шалгалтын үр дүнд илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br><br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулсан байна. | | Хугацаа болоогүй. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хувь 87.5 байсан. | | | | |
| 1.12.1.4 | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Хяналт шалгалт хийсэн объектын зөрчил арилалтын хувь | Нийт өргөдөл , албан бичиг 39 ирсэн. Үүнээс:<br>Нийт албан бичгийн хариутай 37, хариугүй 2, шийдвэрлэсэн 37 буюу 94.8%, хугацаа хоцорч шийдвэрлэсэн байхгүй. | Орон нутгийн хэмжээнд батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна<br>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | | Тайлант хугацаанд Уулбаян, Дарьганга сумын Засаг дарга, Мөнххаан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нараас албан бичгээр ирүүлсэн хүсэлт, 4 иргэнээс гаргасан гомдол мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 1 өргөдлийн хариуг хуулийн хугацаанд хүргүүлж, 4 иргэнд ЗТХ-ийн 8.1.10.1 дэх заалтын дагуу 2 сая төгрөгийн торгууль ноогдуулж ажиллалаа. 2 хүсэлтийг шийдвэрлэхээр ажиллаж байна. | 100 |
